

screen communications and make training for columnists and reporters more significant.

## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

### ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

#### “ЛАМ НАРЫН АСУУДАЛ” СЭТГҮҮЛИЙН ТУХАЙ

Л.Норовсүрэн\*, Ө.Адъяа\*\* (БНХАУ)

\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн гэрээт профессор, Шинжлэх ухааны доктор (Sc.D)

\*\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

**Түлхүүр үг:** лам нар, бичиг үсэг, клуб, багш, аж ахуй, пүүс, Япон, зүүнтэн, бослого тэмцэл, чинээлэг ард, төвд, эрдэмтэн, монгол аялгуу, хөрвүүлэх, өгүүлэл, шашины захиргаа, ялгаварласан бодлого, сүм хийд, ардын сургууль, хоморголон устгах, удирдагч, анагаах ухаан, соёл боловсрол, судалгаа, төр засаг

**1** 921 онд ялсан үндэсний ардчилсан хувьсгалыг гүнзгийрүүлэх зорилтын ээдрээтэй асуудлын нэг нь шашин, сүм хийд, лам нарын асуудал байлаа. Монголын нам, төрөөс эхний үед сүм хийд, лам нарын асуудлаар харьцангуй уян хатан бодлого барьж, тэднийг үндэсний бичиг үсэгт сургах, залуу лам нарыг хар болохыг урамшуулж дэмжлэг үзүүлэх, лам нарын тухайд анги ялгаварласан бодлого баримталж, тэдний дунд нам, засгийн бодлогыг тайлбарлан таниулах зэрэг ажлыг дэс дараатай хэрэгжүүлж байлаа. Гучаад

оны дунд үе латин үсэг сурахыг зогсоож, монгол бичгийг бүх нийтээр сурах хөдөлгөөн өрнүүлсэн жилүүд байв. Ялангуяа нийт эрчүүдийн 40 орчим хувийг эзэлж байсан лам нарыг үндэсний бичиг үсэгт сургахыг ихээхэн чухалчилж байв. Бичиг үсэг сурах явдлыгсайн дурын үндсэн дээр хэрэгжүүлж байсныг зогсоож, сумын захиргаа, клуб, улаан булан, хүрээ хийдийн дэргэд байгуулсан бүлгэм, дугуйланд зохион байгуулалттайгаар хамруулан сургах болсон байна. Лам нарын бичиг үсгийн сургуульд эхний үед бичиг үсгийн багш ажиллуулж байснаа явцын дундаас бичиг үсэг сайн сурсан лам нарыг багшлуулах болжээ. Энэ ажлын үр дүнд зөвхөн 1935-1937 оны хооронд хорин мянга гаруй залуу лам бичиг үсгийн бүлгэмд хамрагдсан байна. Хориод оны сүүлийн хагасаас тус улсын зах зээлээс гадаадын капиталыг шахан зайлуулах, чинээлэг аж ахуйг хавчин хязгаарлаж, феодалын болон томоохон аж ахуйдыг эдийн засаг, улс

төрийн талаар довтолж ангич бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Тухайн үеийн Монгол оронд гадаадын 1000 гаруй пүүс байсны 80 орчим хувь нь Хятадын, үлдэх хэсэг нь Герман, Франц, Орос, Япон, Америк, Англи, Итали, Энэтхэг, Дани зэрэг олон оронд ноогдож байжээ.

Энэ үед мал сүргийн олонх нь чинээлэг ард болон сүм хийдийн мэдэлд байв. Ардын нам, Засгийн газраас феодалын болон сүм хийдийн мал хөрөнгийг хураах, нударган хэмээгдэж байсан чинээлэг ардыг хавчих, лам нарыг хүчээр хар болгож, аж ахуйд шилжүүлэх кампанит ажлыг хүчээр зохион байгуулжээ. Улс орныхоо өвөрмөц нөхцөл байдлыг үл харгалзан зүүнтний хийсэн энэ хүчирхийллийн улмаас ардын бослого тэмцэл газар сайгүй өрнөж, олон мянган айл өрх хил даван дүрвэж, нам, засгийн нэр хүнд унаж, иргэний дайн гарах ирмэгт тулж очсон байна. Зүүнтний хийсэн энэ нугалааны хор уршгийг арилгах тэмцлийн үед “Лам нарын асуудал” сэтгүүл гарсан юм.

“**Л**ам нарын асуудал” сэтгүүлийн нийт зургаан дугаар гарсан гэдэг боловч нэг гарахдаа хоёр дугаарыг хамтатган хэвлэдэг байсан учир үнэн хэрэгтээ гурван дэвтэр л гаргасан байдаг. 1936 онд №1, 2, 1937 онд №3, 4 болон №5, 6 нь гарчээ. 1936 оны дугаар нь төвд үсгээр эхэлж хэвлээд, монголыг хадсан байна. Энэ нь лам нар толгой дараалан мэддэг төвд бичгээрээ уншаад монгол бичгийг харьцуулж сурахад зориулагдсан бол, 1937 оны дугааруудыг монгол бичгээр эхэлж гаргаад, төвдийг хадаж өгсөн байна. Энэ нь олонх лам нар үндэснийхээ бичиг үсгийг сурсан нөхцөлд монголоор эхэлж уншаад ээдрээтэй үг,

үсгийг төвдтэйгөө харьцуулж үзэхэд зориулагджээ.

“Лам нарын асуудал” сэтгүүлийг монгол, төвд хоёр бичгээр хадмаллан гаргаж байсан нь гадаад, дотоодын бичиг үсэг судлаачдын анхаарлыг татсаар ирсэн байдаг. Ялангуяа монгол хэл, төвд үсгээр бичсэн зохиол бүтээлүүд тэдний анхаарлыг их татдаг. Энэ асуудлаар анх Данийн эрдэмтэн Кааре Грөнбэч 1953 онд “Mongolian in Tibetan script” гэдэг өгүүлэл бичиж “Studia Orientalia” сэтгүүлд нийтлүүлсэн билээ. Тэрээр уг өгүүлэлдээ төвд үсгээр монгол хэлээр бичих явдал бол лам нарын хувьд тогтсон хэм хэмжээ мөн гээд “Лам нар амаар хоёр хэл рүү хөрвүүлж чадах хэдий ч санаагаа бичгээр илэрийлэхдээ гагцхүү сайн мэддэг төвд үсгээрээ илэрхийлэх нь түгээмэл байсан”<sup>1</sup> хэмээн дүгнэжээ. Үүнээс өмнө Оросын эрдэмтэн А.М.Позднеев 1887 онд бичсэн “XIX зууны сүүл үеийн Монголын ламын шашин”, Алаксей Бобровников 1849 онд Казаньд хэвлүүлсэн “Монгол-Халимаг хэлний зүй” гэдэг номондоо дээрх санааг тус тус тэмдэглэж байжээ. Монголын эрдэмтдээс профессор Т.Пагва 1957 онд “Төвд үсгээр үгчилсэн монгол ном зохиол” гэдэг өгүүлэл бичиж үсэг зүй, зөв бичгийн шинжилгээ хийсэн бол, академич Ц.Дамдинсүрэн 1959 онд “Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой” хэмээх дээж бичигтээ Гэлэгбалсангийн төвд үсгээр, монгол хэлээр бичсэн “Наадмын ерөөл” шүлгийг оруулж товч тайлбар хийсэн байдаг. Мөн онд бас академич Б.Ринчен Ишдоржийн төвд үсгээр зохиосон “Төвд-Монгол толь”-ийг хэвлүүлж “Монгол үгийг төвд үсгээр өөрийн нутгийн аялгууг баримтлан, аман бичгийн хэлний байдлаар

тэмдэглэсэн нь монгол аялгууг судлах монголч эрдэмтэнд маш сонин чухал зүйл болжээ” хэмээн тэмдэглэсэн билээ.

1960 онд Английн монголч эрдэмтэн Чарльз Боудэн “Mongolian in Tibetan script” хэмээх Кааре Грөнбэчийнхтэй ижилхэн нэртэй өгүүлэл бичиж “StudiaOrientalia” сэтгүүлд нийтлүүлжээ. Гэвч Т.Пагва, Ч.Боудэн нар цухас дурьдсаныг эс тооцвол эдгээр ном бүтээлд “Лам нарын асуудал” сэтгүүлийн талаар лавшруулан судалсан зүйл үгүй байна. Өрнөдийн эрдэмтдээс тус сэтгүүлийн талаар нэлээд тодорхой дүгнэлт хийсэн хүн бол Америкийн судлаач Степани Гривелет юм. Тэрээр 2001 онд Индианы Их Сургуулийн Монголын нийгэмлэгийн сэтгүүлд 1936 онд гарсан “Лам нарын асуудал” сэтгүүлийн нийтлэлийг хуулж, судалгааны өгүүллийн хамт “The Journal of The Lamas: A Mongolian publication in Tibetan script” гэсэн гарчигтайгаар нийтлүүлсэн байна. С.Гривелет “Хоёр бичгээр хадмаллан гаргасан “Лам нарын асуудал” сэтгүүл нь төвд бичигтэй лам нараас монгол бичгийг ойлгоход нь тус болж байсны зэрэгцээгээр бичиг үсгийн судалгааны салбарт үнэтэй чухал баримт болсон”<sup>2</sup> хэмээн дүгнэсэн бол, Монголын судлаач Л.Чулуунбаатар МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичгийн 2012 оны 35(367) дугаарт “Лам нарын сэтгүүлийн тухай” гэдэг өгүүлэл нийтлүүлж, түүндээ тус сэтгүүлийн төвд, монгол хоёр бичвэрийн үсэг оноосон байдалд Степани Гривелетийн хийсэн дүгнэлтийг өндөр үнэлсэн байдаг<sup>3</sup>. Л.Чулуунбаатар уг өгүүллийнхээ төгсгөлд “Лам нарын асуудал” сэтгүүлийн 1936, 1937 оны дугаарт гарсан нийтлэлүүдийн гарчгийг

жагсааж, “Сэтгүүлийн хамгийн гол зорилго бол лам нарыг монгол бичигт сургах, худал ташаа мэдээллийг арилгаж, лам нарт үнэн зөв мэдээлэл хүргэх явдал байсан”<sup>4</sup> хэмээн дүгнэсэн байна.

**Т**ус сэтгүүлд нийтлэгдсэн “Шашны захиргааны есдүгээр Их хурлын тогтоол” гэсэн материалд “Шашин номын хэргийг эрхэлсэн нэгэн хэсэг лам бид нар нь угаас монгол хүн болохыг хэрхэвч умартаж үл болох тул өөрийн үндэс язгуур ба засаг төр хийгээд ардын үндэсний соёл боловсролыг дээшлүүлэх хэрэгт санаа зовнин туслалцах нь чухал хэмээн үзмүй. Ер ч үндэсний монгол бичгийг суралцах явдал нь Монголын ард түмний соёл боловсролыг дээшлүүлэх ба тусгаар тогтносон засаг төрийг улмаар батжуулах явдалд хамгийн чухал нөхцөл мөн болмой”<sup>5</sup> гэж уг тогтоолд заасныг онцлон тэмдэглэсэн байна. Үүнээс үзвэл тус сэтгүүл лам нарыг бичиг үсэгт сургах явдлын чухлыг олон нийтэд ойлгуулахын зэрэгцээ өөрийн гэрэлт хуудсыг үндэсний бичиг үсэг сурах талбар болгож байсныг мэдэж болно. Түүнчлэн лам нарын асуудлыг анги ялгаварласан бодлогоор алгуур аажим шийдвэрлэхээр зорьж байсан нам, засгийн бодлогыг гажуудуулж, тэднийг хавтгайруулан довтолсон зүүнтний алдааг засч, лам нарыг ард түмний талд татах зорилтыг хэрэгжүүлэхэд сэтгүүл нийтлэлийн бодлогоо чиглүүлж байжээ. Сэтгүүл бас нугалааны үед дунд лам нарыг эсэргүү хэрэгт хилсээр холбогдуулсан завхралыг хянан үзэж, гэм зэмгүй хүмүүсийг суллаж байгаа, хар болсон лам нарт сонгуулийн эрх эдлүүлэх болсон, албаар хар болсон лам нарыг эргэж лам болох нөхцлийг бүрдүүлсэн зэргийг сайшаан тэмдэглэж, уг шийд-

вэрийн ачаар зүүний алдааг зассан эхний хоёрхон жилд 27 мянга гаруй хүн дахин лам болж, олон мянган гэмгүй лам цагаадсан<sup>6</sup> тухай мэдээлж байжээ. Сүм хийдийг албадан хаах, хууль бусаар нэгжих, хурал номын үйл ажиллагааг зүй бусаар үймүүлэхийг хориглосон, сүм хийд өөрийн харъяа жасдаа бүрэн эзэн байх эрхийг сэргээсэн<sup>7</sup> зэргийг сэтгүүл мэдээлж байв. Эдгээр арга хэмжээний дараа буюу 1936 он гэхэд улс орны хэмжээнд том, жижиг сүм хийд, хурлын газар 840 гаруй<sup>8</sup> байсан бөгөөд тэдгээрт 90 мянга орчим лам сууж байсны 18 мянга нь<sup>9</sup> сургуулийн насны хүүхэд байжээ. Шашны хурал номын нэг газарт дунджаар 900 орчим хүн, нэг ламд 10 хүн, гурван өрх оногдож байв. Лам нарын хэрэгцээнд жилд ойролцоогоор 30 гаруй сая төгрөгийн хөрөнгө зарцуулж байсан нь тухайн үеийн ардын сургуулиудын нэг жилийн зардлаас 16 дахин их байжээ<sup>10</sup>. Засгийн газар ийм байдлыг анхааралдаа авч лам нарыг аль болохоор гэгээрүүлж, нийгмийн тустай хөдөлмөрт татан оруулах бодлогыг барьж, үйлдвэр аж ахуйн ажилд шилжсэн ламт улсаас элдэв тусламж үзүүлж, татвараас чөлөөлж байв. Зөвхөн 1936 онд аж ахуйд гарсан лам нарт зориулж улсаас 500 мянган төгрөгийн зээллэгийн сан байгуулж, хөдөө аж ахуйд гарсан 200 ламд 100 гаруй мянган төгрөгийн зээл олгожээ<sup>11</sup>. Дээрх тоо баримтуудаас харахад тухайн үед шарын шашин урьдын адил нөлөөтэй хэвээр байсан хийгээд, лам нарын тоог хорогдуулж нийгмийн идэвхтэй иргэд болгож хувиргахад хичнээн их хүч хөрөнгө зарцуулж байсан нь тодорхой байна. Лам нарыг нийгмийн хөдөлмөрт татан оруулах оновчтой аргын нэг нь Лам нарын артель байв. Ардын засгийн

газар доод лам нарыг үйлдвэр, аж ахуйн газруудад татан оруулах ажлыг 1935 оноос эхлэн туршиж үзсэний үндсэн дээр 1937-1938 онд тухайлсан хөдөлгөөн болгон өрнүүлж зөвхөн 1938 онд ядуу лам нарын гар үйлдвэрлэлийн 120 артель байгуулагдаж, түүнд 5000 гаруй лам хамрагдах болсон<sup>12</sup> байна.

**М**онгол оронд нийгэм улс төрийн нөхцөл байдлыг харгалзан хүлээцтэй, уян хатан байдлаар хэрэгжиж байсан лам нарын асуудал хөндлөнгийн шалтгаанаар гажуудаж, улмаар улс төрийн хэлмэгдүүлэлт болон хувирсан юм. Дэлхийн II дайны гал Дорно зүгээс ноцож эхлэх үеэс Зөвлөлтийн удирдагч И.В.Сталин Монгол орныг найдвартай ар талаа болохыг эрмэлзэж эхэлжээ. Тэрээр нам, төрийн гол удирдагч П.Гэндэн, А.Амар, Х.Чойбалсан нарыг удаа дараалан дуудаж уулзахдаа хар шар, феодал болон лам нарыг бүрэн устгахыг шаардаж байв. Ялангуяа лам нарыг ангийн дайсан хэмээн үзэж устгахыг Сталин шаргуу шаардаж байлаа. Уг шаардлагыг П.Гэндэн “Манай улс хүн ам цөөтэй учир лам нараа хар болгож ажил хийлгэнэ”<sup>13</sup>, “...тус улсын гадаад байдал түгшүүртэй байх үед лам нарын асуудлыг хурцатгаж, тэдэнтэй тэмцэх гэсэн хүн бол хувьсгалын эсэргүү болно”<sup>14</sup> гэж лам нарыг тууштай хамгаалж байв. Гэвч Монголын удирдагчид их гүрний шахалтаар сүм хийд, лам нарыг хоморголон устгах ажлыг эхлүүлсэн байдаг.

“Лам нарын асуудал” сэтгүүлд нийтлэгдсэн “Лам нарын тухай засгийн бодлого”, “Лам хүүхдийн бичиг үсгийн сургууль”, “Лам нарт таниулах хэмээсэн товч өгүүлэл”, “Лам нарын дотор үүсч буй үйлдвэрийн тухай

илтгэл ба тайлан”, “Орлого бүхий лам нарт албан татвар ноогдсон тухай”, “Манай улсын доторх олон хүрээ хийдийн дотор юу болж байгаа буй” гэх мэт өгүүлэл, мэдээллүүдээс гучаад оны хоёрдугаар хагаст сүм хийд, лам нарын талаар явуулж байсан бодлого, үйл ажиллагааг тодорхой мэдэж болно. Тус сэтгүүл лам нарт зориулагдсан тул тэднийг цаг үеэ мэдэрч, шинэ цагийн аясыг даган амьдралын хэвшлээ өөрчлөхийг аядуу зөөлөн аргаар ухуулж, урамшуулж туслах, шүүмжилж ойлгуулах аргыг хослон хэрэглэж байжээ. Хэт нэг талыг барьж хатуурхвал лам нарын дургүйг хүргэж сэтгүүл уншигчаа алдахаас болгоомжилж байжээ. “Орон нутгийн сурвалжлагч нар ба бусад лам нараас бичсэн санал шүүмжлэлүүд”, “Орон нутгийн сайшаал ба тусламжууд”, “Лам хүүхдийн бичиг үсгийн сургууль”, “Орон нутгийн тусламж ба захидлууд” зэрэг өгүүлэл материалд Ардын засгийн газраас лам нарын талаар авч хэрэгжүүлж байгаа ажил, тэдэнд үзүүлж байгаа тусламж дэмжлэг, түүнд баярлаж талархсан лам нарын сэтгэгдэл, санал хүсэлт зэргийг илэрхийлсэн байна. Засгийн газраас ийнхүү харж үзэж, дэмжиж тусалж байгааг үл хэрэгсэн ард түмний дунд элдэв өөдөө сөөргөө үг яриа гаргаж яваа том лам нарын зүй бус явдлыг илчилж шүүмжилсэн зүйл ч гарч байв. “Зарим хуурамч явдлыг илрүүлэн шүүмжлэх нь”, “Үнэн худлын тодорхой

ялгавар хэмээх оршвой”, “Улсын дээд шүүхээс тасалсан нэгэн хэрэг”, “Лам нарт таниулах хэмээсэн товч өгүүлэл”, “Сэтгүүлийн хашаанд орхисон нэргүй бичгийн хариу” гэх мэт шүүмжлэлт өгүүлэл материал нийтэлжээ. Тухайлбал “Монголын доторх лам нарт хэлэх учиртай хэдэн үгийн залгаа” гэдэг өгүүлэлд лам нарын урьд, одоог харьцуулж, зарим лам нар мөнгөн хазаар, хударгатай морь унаж, шар торгон хүрэм өмсөж, сан жасын мал тоолох нэрээр энд тэнд явахдаа ардуудаас өргөл барьц авч, хонь гаргуулж, ядуу ардыг хохируулж байгаа тухай тодорхой баримттайгаар шүүмжилсэн байдаг.

Харин тухайн үед гарч байсан бусад хэвлэл хутагт хувилгаад зэрэг том лам нарын харгис хэрцгий, сувдаг шунахай, юм мэддэггүй, харанхуй бүдүүлгийг шүүмжилсэн зүйлийг арвин нийтэлж байжээ. Ийм нийтлэлийн тоонд “Ардын эх” сонинд нийтлэгдсэн “Ариун, бузрыг ялгая”, “Хувилгаан хэмээсэн нь чөтгөр болжээ”<sup>15</sup> зэргийг нэрлэж болно.

“Хувилгаан хэмээсэн нь чөтгөр болжээ” гэдэг нийтлэлд Цэцэн ханы хошууны хүрээнд цагаан бурхан хэмээх халдварт өвчин гарсан даруйд сургуулийн хүүхдүүдийг тарьж эмчилж байсныг хувилгаан гэгдэх лам хориглон зогсоосноос болж тарилга хийлгэсэн арван хүүхдээс бусад нь цөм нас барсан тухай мэдээлээд, тэрхүү хувилгаан хэмээгдэх ламыг олон хүний амийг



***Тус сэтгүүл лам нарт зориулагдсан тул тэднийг цаг үеэ мэдэрч, шинэ цагийн аясыг даган амьдралын хэвшлээ өөрчлөхийг аядуу зөөлөн аргаар ухуулж, урамшуулж туслах, шүүмжилж ойлгуулах аргыг хослон хэрэглэж байжээ. Хэт нэг талыг барьж хатуурхвал лам нарын дургүйг хүргэж сэтгүүл уншигчаа алдахаас болгоомжилж байжээ***



санаатай хорлосонтой адилтган үзэж хатуу цээрлүүлэхийг шаардсан байна. Энэ тухай хэвлэлийн түүх судлаач Г.Дэлэг “Иймэрхүү мэдээ үе үе гаргаж байсан нь лам нар, хутагт хувилгаадын юм мэддэггүй, харанхуй мунхгийг харуулахын зэрэгцээ, анагаах ухааны ач тусыг амьд тодорхой жишээгээр хүмүүсийн ой тойнд ортол харуулан, ард түмэн, тэдний үр хүүхдийг эрдэм соёлын зүг уриалан дуудаж байлаа”<sup>16</sup> хэмээн дүгнэсэн байна.

“**Л**ам нарын асуудал” сэтгүүлийг үзэж судалсны үндсэн дээр дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1. Тус сэтгүүл Монгол оронд ардчилсан хувьсгалыг төгөлдөржүүлэх цаг үеийн шаардлагаар гарсан байна.

2. Сэтгүүл Ардын засаг төрөөс шашин сүм хийд, лам нарын талаар явуулж байсан дэс дараатай, уян хатан бодлогыг боломжийн хэрээр сурталчилж байжээ.

3. Лам нарыг үндэсний бичиг үсэгт сургаж, сайн дурын үндсэн дээр хар болж, эх орныхоо бүтээн байгуулах хөдөлмөрт хүчин зүтгэдэг идэвхтэй иргэд болгон хувиргах явдал тус сэтгүүлийн нийтлэлийн бодлогын цөм болж байжээ.

4. Сүм хийдийн хурал номыг үймүүлэх, албадан хаах, лам нарыг хүчээр хар болгох, хилс хэрэгт холбогдуулах зэрэг нугалаа гаргаж байсан Зүүнтний алдааг засахад сэтгүүл чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

5. Монголын лам нарыг хувьсгалын эсэргүү, ангийн дайсан хэмээн үзэж бүрмөсөн устгахыг зорьсон И.В.Сталин тэргүүтэй Зөвлөлт засгийн газар,

Коминтерний хүчинд автан шашин, лам нарыг хэлмэгдүүлэх кампанит ажил эхэлсэнтэй холбоотойгоор “Лам нарын асуудал” сэтгүүл гаралтаа зогсоосон байна.

### Ишлэл

<sup>1</sup>Каара Грөнбэч. 1953. “Mongolian in Tibetan script”. Studia Orientalia. p.32.

<sup>2</sup>Stephane Grivelet. 2001. “The Journal of The Lamas: A Mongolian publication in Tibetan script”. Bloomington. p6.

<sup>3</sup>Чулуунбаатар Л. 2012. Лам нарын сэтгүүлийн тухай. МУИС-ийн ЭШБ. №35 (367). 263 дахь тал.

<sup>4</sup>Чулуунбаатар Л. 2012. Лам нарын сэтгүүлийн тухай. МУИС-ийн ЭШБ. №35 (367). 266-267 дахь тал.

<sup>5</sup>“Лам нарын асуудал” сэтгүүл. 1936. № 3, 4. 100-104 дэх тал.

<sup>6</sup>Нийгмийг Аюулаас Хамгаалах байгууллагын архив. “1935 оны сүм хийдийн талаар гаргасан дэлгэрэнгүй илтгэл”.

<sup>7</sup>1969. БНМАУ-ын түүх. (Гутгаар боть). УБ., 301 дэх тал.

<sup>8</sup>МАХН-ын Төв архив. Ф.1, Хн.7. 124 дэх тал.

<sup>9</sup>1934. МАХН-ын IX их хурал дээр үндэсний соёл боловсролыг хөгжүүлэхэд намаас тавих зорилтын тухай илтгэл. УБ., 13 дахь тал.

<sup>10</sup>1969. БНМАУ-ын түүх. (Гутгаар боть).УБ., 342 дахь тал.

<sup>11</sup>МАНХН-ын Төв архив. Ф.1, т.6. Хн.51. 81 дэх тал.

<sup>12</sup>1940. БНМАУ-ын Гар үйлдвэрлэлийн хоршооллын анхдугаар Их хурлын тогтоол. УБ., 33-35 дахь тал.

<sup>13</sup>Отгонжаргал С. 2003. XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй.(1921-1990). УБ., 73 дахь тал.

<sup>14</sup>1969. БНМАУ-ын түүх. (Гутгаар боть). УБ., 356 дахь тал.

<sup>15</sup>“Ардын эрх” сонин. 1924. №4.

<sup>16</sup>Дэлэг Г. 2014. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ., 276 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Каара Грөнбэч. 1953. “Mongolian in Tibetan script”. Studia Orientalia.

2. *Stephane Grivelet*. 2001. "The Journal of The Lamas: A Mongolian publication in Tibetan script". Bloomington.
3. *Чулуунбаатар Л.* 2012. Лам нарын сэтгүүлийн тухай. МУИС-ийн ЭШБ. №35 (367).
4. "Лам нарын асуудал" сэтгүүл. 1936. № 3, 4.
5. Нийгмийг Аюулаас Хамгаалах байгууллагын архив. "1935 оны сүм хийдийн талаар гаргасан дэлгэрэнгүй илтгэл".
6. 1969. БНМАУ-ын түүх. (Гутгаар боть). УБ.,
7. МАХН-ын Төв архив. Ф.1, Хн.7.
8. 1934. МАХН-ын IX их хурал дээр үндэсний соёл боловсролыг хөгжүүлэхэд намаас тавих зорилтын тухай илтгэл. УБ.,
9. 1940. БНМАУ-ын Гар үйлдвэрлэлийн хоршооллын анхдугаар Их хурлын тогтоол. УБ.,
10. *Отгонжаргал С.* 2003. XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй. (1921-1990). УБ.,
11. "Ардын эрх" сонин. 1924. № 4.

### Summary

On journal "Issues of monks". In this article the mission, social role, role for correcting the leftist deviation on religion, monasteries and temples, as well as main topics of discussions of the journal "Issues of monks" published between 1936-1937, were discussed.